



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар

А/ЭЧ

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйл, Ерөө сумын Засаг даргын саналыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 7.1.2, 11.1.7, 12.4.4, 12.4.5, 8 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.1.1 заалтуудыг тус тус зөрчсөн Ерөө сумын "Рашаант олон нуур" ХХК-ий "Олон нуур" хүнсний дэлгүүрийн "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийг цуцалсугай.

2.Тусгай зөвшөөрөл цуцлагдсан аж ахуйн нэгжид хоёр жилийн дотор дахин зөвшөөрөл олгохгүй байхыг "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих" ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

3.Тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Энхбаяр, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Энхсайханд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Н.БАТДОРЖ